



БАТЛАВ.



ШИНЭ КОРОНАВИРУСТ ХАЛДВАР (COVID-2019)-ЫН ҮЕД ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХЭД ШААРДЛАГАТАЙ ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЭЛ, НИЙЛҮҮЛЭХ ГЭРЭЭ

Дугаар № 79

Улаанбаатар хот

Нэг талаас Эрүүл мэндийн яам (цаашид "захиалагч" гэх), нөгөө талаас ЭНТО ХХК (цаашид "нийлүүлэгч" гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож 2020 оны 03 дугаар сарын 17-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид "гэрээ" гэх) байгуулав.

- Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
- Эм худалдан авах гэрээг (цаашид "бараа" гэх) 394,000,000 (гурван зуун ерэн дөрвөн сая) төгрөгөөр (цаашид "гэрээний үнэ" гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.

Хүснэгт 1. Нийлүүлэх бараа

Д/д	Барааны нэр, төрөл	Багцийн дугаар	Үйлдвэрлэгч, Улс	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгж үнэ /НӨАТ орсон/	Нийт үнэ
1	Амоксициллин + Клавулоны хүчил	6	ОХУ - Kraspharma JSC	Фл	1,500	4,000	6,000,000
2	Альбумин	17	БНСУ - SK Plasma Co., Ltd.	фл	2,000	194,000	388,000,000
Нийт дүн							394,000,000

- Захиалагч нь барааны нийлүүлэлтийг 394,000,000 (гурван зуун ерэн дөрвөн сая) төгрөгийг Засгийн газрын нөөц хөрөнгөөр санхүүжүүлнэ.
- Нийлүүлэгч нь 2 нэр төрлийн барааг 2020 оны 03 дугаар сарын 17-ны өдрөөс 2020 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.

3. Дор дурдсан бичиг баримт нь гэрээний хэсэг болно (цаашид "гэрээний баримт бичиг" гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
Бусад шаардлагатай баримт бичиг¹;
Тендер ба үнийн хуваарь;
Гэрээний тусгай нөхцөл;
Гэрээний ерөнхий нөхцөл;
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;
Санхүүжилтийн хуваарь.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

4. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хариуцлагыг хүлээж байна.
5. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг хариуцлага хүлээж байна.
6. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

Хүснэгт 2. Санхүүжилтийн хуваарь

Д/Д	Барааны нэр, төрөл	Багцийн дугаар	Гэрээний үнийн 100 хувьтай тэнцэх дүнг эм, эмнэлгийн хэрэгслийг хүлээлгэн өгснөөс хойш 30 хоногийн дотор нэхэмжлэх (Захиалагчийн нэр, хаягийг бичиж, барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан, гарын үсэг, тамга тэмдгээр баталгаажуулсан байна)
1	Амоксициллин + Клавулоны хүчил	6	6,000,000
2	Альбумин 20% 100мл	17	388,000,000
	Нийт дүн		394,000,000

¹ Хоёр тал харилцан тохиролцож гэрээний нөхцөлд оруулсан зайлшгүй шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүд.

ГЕН 30

Монгол Улсын нутаг дэвсгэрийн гаднаас болон дотоодоос нийлүүлэх эм, эмнэлгийн хэрэгсэл, ариутгалын бодисыг зориулалтын тээврийн хэрэгслээр тээвэрлэн ХӨСҮТ-д болон эцсийн цэгт захиалагчид хүргэх хүртэл оногдуулсан бүх татвар хураамж, тээвэр, даатгал болон бусад зардлыг нийлүүлэгч бүрэн хариуцна.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

Эрүүл мэндийн яамны Эм, эмнэлгийн хэрэгсэл, үйлдвэрлэлийн хэлтсийн дарга

..... Г.Цэцэнсанаа

Эрүүл мэндийн яамны Хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга

..... Т.Бямбасүрэн

Эрүүл мэндийн яамны Эм, эмнэлгийн хэрэгсэл, үйлдвэрлэлийн хэлтсийн мэргэжилтэн

..... Т.Мөнхтуул

Эрүүл мэндийн яамны Хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн

..... Г.Бат-Эрдэнэ

Эрүүл мэндийн яамны нягтлан Бодогч

..... Э.Эрдэнэцэцэг

Эрүүл мэндийн яамны хуулийн хэлтсийн Мэргэжилтэн

..... Д.Мөнхцэцэг

14210 Улаанбаатар хот Сүхбаатар дүүрэг Олимпийн гудамж 2, Засгийн газрын VIII байр

Утас: 263695

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЖ

Бүтээгдэхүүн хөгжүүлэлт төлөвлөлтийн албаны дарга

..... Л.Золзаяа

Хаяг: СБД, 1-р хороо, World market 301 тоот
Утас: 70121211

Харилцах банк: Худалдаа хөгжлийн банк
Дансны дугаар: 405028347